

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2024/94/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Баян-Өлгий аймаг
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 99932710 Цахим хаяг:
jenisbekh@audit.gov.mn

Аудитор: Х.Манаргүл
Утас: 95429524 Цахим хаяг: manargulx@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт	Error! Bookmark not defined.
5.2 Албан шаардлага	Error! Bookmark not defined.
5.3 Зөвлөмж	Error! Bookmark not defined.
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

 БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 83129 Өлгий, Баян-Өлгий аймаг, Утас/Факс: (976) 7042-2954 E-mail: bayanulgii@audit.gov.mn	НОГООННУУР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 1 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Ш.РАЯ ТАНАА
2024.02.22 № 171	
танай _____-ны № _____-т	
Өөрчлөлтгүй дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p> <p>Дүгнэлтийн үндэслэл</p> <p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p> <p>Асуудлыг онцолсон хэсэг</p> <p>Тайлант онд онцлох үйл явдал гараагүй байна.</p> <p>Аудитын гол асуудал</p> <p>Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.</p> <p>Бусад асуудлын хэсэг</p> <p>Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.</p> <p>Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага</p>	
00402257	

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>428,849,738.00</u>	<u>668,338,673.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	43,259,557.00	289,870,582.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	43,259,557.00	289,870,582.00
3121	Төгрөг	43,259,557.00	289,870,582.00
31211	Төрийн сангийн харилцах	43,259,557.00	289,870,582.00
33	АВЛАГА	72,126,150.00	32,602,000.00
335	Бусад авлага	72,126,150.00	32,602,000.00
3351	Байгууллагаас авах авлага	72,126,150.00	32,602,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	313,464,031.00	345,866,091.00
354	Хангамжийн материал	277,884,031.00	311,706,091.00
35410	Бичиг хэргийн материал	62,350.00	-
35420	Аж ахуйн материал	174,343,837.00	191,890,635.00
35440	Түлш, шатах тослох материал	5,888,359.00	14,825,066.00
35460	Хүнсний материал	52,562,750.00	59,963,655.00
35470	Бусад хангамжийн материал	45,026,735.00	45,026,735.00
35600	Мал амьтад	35,580,000.00	34,160,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,619,287,855.05</u>	<u>1,705,147,160.77</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,619,287,855.05	1,705,147,160.77
392	Биет хөрөнгө	1,563,408,855.09	1,625,178,083.80
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,742,731,660.38	1,820,677,451.38
39202	Хуримтлагдсан элэгдэл	(317,636,968.57)	(408,963,759.49)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	74,599,826.00	171,342,976.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(36,542,182.58)	(64,294,014.28)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	63,582,915.00	74,696,915.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(36,904,885.14)	(42,988,671.73)
39209	Зам, гүүрийн байгууламж	8,000,000.00	8,000,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-	(311,111.08)
39214	Бусад үндсэн хөрөнгө	69,429,827.00	66,199,327.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(69,429,827.00)	(66,199,327.00)
39217	Ном	65,578,490.00	67,018,298.00
393	Биет бус хөрөнгө	55,878,999.96	79,969,076.97
39301	Програм хангамж	550,000.00	18,821,239.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(275,000.04)	(456,162.03)
39303	Бусад биет бус хөрөнгө	55,604,000.00	61,604,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,048,137,593.05</u>	<u>2,373,485,833.77</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,048,137,593.05</u>	<u>2,373,485,833.77</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,048,137,593.05	2,373,485,833.77
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	465,200,088.00	471,200,088.00
512	Хуримтлагдсан үр дүн	(318,841,019.83)	507,220.89
51210	Өмнөх үеийн үр дүн	(318,841,019.83)	(318,841,019.83)

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51220	Тайлант үеийн үр дүн	-	319,348,240.72
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,901,778,524.88	1,901,778,524.88
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,048,137,593.05</u>	<u>2,373,485,833.77</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,412,492,138.00	3,156,976,036.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,200,000.00	133,837,588.00
120	Нийтлэг татварын бус орлого	13,200,000.00	133,837,588.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	13,200,000.00	10,200,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,200,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	8,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	13,200,000.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	94,704,338.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	-	28,933,250.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,399,292,138.00	3,023,138,448.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,396,692,138.00	3,022,987,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	179,001,000.00	75,968,000.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	34,970,738.00	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,182,720,400.00	2,947,019,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,600,000.00	150,648.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,600,000.00	150,648.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,337,527,328.33	2,837,627,795.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,337,527,328.33	2,837,627,795.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,241,315,659.33	2,743,195,160.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,600,143,129.00	2,014,845,235.00
210101	Үндсэн цалин	1,216,987,540.00	1,371,547,704.00
210102	Нэмэгдэл	332,688,180.00	542,859,735.00
210104	Урамшуулал	50,467,409.00	100,437,796.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	201,731,747.00	245,632,152.00
210201	Тэтгэврийн даатгал	138,459,047.00	158,608,452.00
210202	Тэтгэмжийн даатгал	15,955,300.00	21,755,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,763,700.00	17,404,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,190,700.00	4,351,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	31,363,000.00	43,512,300.00

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,424,955.00	65,931,293.00
210301	Гэрэл, цахилгаан	8,929,620.00	9,033,908.00
210302	Түлш, халаалт	64,495,335.00	56,897,385.00
2105	Нормативт зардал	193,875,458.00	202,902,265.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	244,350.00	-
210502	Хоол, хүнс	193,631,108.00	202,902,265.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,081,000.00	1,100,000.00
210604	Урсгал засвар	1,081,000.00	1,100,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,981,300.00	15,966,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	2,200,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,981,300.00	13,766,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	167,078,070.33	196,817,615.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,125,200.00	53,252,583.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,954,050.00	17,765,350.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	113,998,820.33	125,799,682.28
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	96,211,669.00	94,432,635.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	96,211,669.00	94,432,635.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	96,211,669.00	94,432,635.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>74,964,809.67</u>	<u>319,348,240.72</u>
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>74,964,809.67</u>	<u>319,348,240.72</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,364,321,400.00</u>	<u>3,033,338,448.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	10,200,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	10,200,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	10,200,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		2,200,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		8,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>2,364,321,400.00</u>	<u>3,023,138,448.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,361,721,400.00	3,022,987,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	179,001,000.00	75,968,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,182,720,400.00	2,947,019,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,600,000.00	150,648.00

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,600,000.00	150,648.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,313,191,843.00</u>	<u>2,747,898,923.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>2,313,191,843.00</u>	<u>2,747,898,923.00</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>2,216,979,943.00</u>	<u>2,647,004,733.00</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,603,633,963.00	2,014,845,235.00
210101	Үндсэн цалин	1,220,478,374.00	1,371,547,704.00
210102	Нэмэгдэл	332,688,180.00	542,859,735.00
210104	Урамшуулал	50,467,409.00	100,437,796.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	198,890,100.00	245,632,152.00
210201	Тэтгэврийн даатгал	135,617,400.00	158,608,452.00
210202	Тэтгэмжийн даатгал	15,955,300.00	21,755,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,763,700.00	17,404,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,190,700.00	4,351,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	31,363,000.00	43,512,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	79,468,000.00	74,868,000.00
210301	Гэрэл, цахилгаан	6,902,089.00	9,033,908.00
210302	Түлш, халаалт	72,565,911.00	65,834,092.00
2105	Нормативт зардал	201,407,300.00	203,841,615.00
210502	Хоол, хүнс	201,407,300.00	203,841,615.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,100,000.00	1,100,000.00
210604	Урсгал засвар	1,100,000.00	1,100,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,034,750.00	15,910,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		2,200,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,034,750.00	13,710,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	120,445,830.00	90,807,131.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	107,036,800.00	70,241,331.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,409,030.00	20,565,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	<u>96,211,900.00</u>	<u>100,894,190.00</u>
2132	Бусад урсгал шилжүүлэг	96,211,900.00	100,894,190.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	96,211,900.00	100,894,190.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>51,129,557.00</u>	<u>285,439,525.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>7,870,000.00</u>	<u>38,828,500.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>7,870,000.00</u>	<u>38,828,500.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	7,870,000.00	38,828,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,870,000.00	38,828,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(7,870,000.00)</u>	<u>(38,828,500.00)</u>

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		43,259,557.00	246,611,025.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			43,259,557.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		43,259,557.00	289,870,582.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	465,200,088.00	1,901,778,524.88	(318,841,019.83)	2,048,137,593.05
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	465,200,088.00	1,901,778,524.88	(318,841,019.83)	2,048,137,593.05
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	465,200,088.00	1,901,778,524.88	(318,841,019.83)	2,048,137,593.05
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	6,000,000.00			6,000,000.00
D08	Тайлант үеийн үр дүн			319,348,240.72	319,348,240.72
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	471,200,088.00	1,901,778,524.88	507,220.89	2,373,485,833.77

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,079,898,100.00	2,786,576,775.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,079,898,100.00	2,786,576,775.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,963,899,100.00	2,685,682,585.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,219,488,700.00	2,014,845,235.00
210101	Үндсэн цалин	1,517,432,900.00	1,371,547,704.00
210102	Нэмэгдэл	608,807,100.00	542,859,735.00
210104	Урамшуулал	93,248,700.00	100,437,796.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	277,436,100.00	245,632,152.00
210201	Тэтгэврийн даатгал	188,656,500.00	158,608,452.00
210202	Тэтгэмжийн даатгал	22,194,900.00	21,755,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,755,900.00	17,404,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,439,000.00	4,351,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	44,389,800.00	43,512,300.00

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	74,868,000.00	74,868,000.00
210301	Гэрэл, цахилгаан	8,668,000.00	9,033,908.00
210302	Түлш, халаалт	66,200,000.00	65,834,092.00
2105	Нормативт зардал	227,533,800.00	203,841,615.00
210502	Хоол, хүнс	227,533,800.00	203,841,615.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,100,000.00	1,100,000.00
210604	Урсгал засвар	1,100,000.00	1,100,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,210,600.00	15,910,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,500,000.00	2,200,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,710,600.00	13,710,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	146,261,900.00	129,484,983.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	125,696,100.00	108,919,183.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,565,800.00	20,565,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	115,999,000.00	100,894,190.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	115,999,000.00	100,894,190.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	115,999,000.00	100,894,190.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,036,487,800.00	3,033,187,800.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,947,019,800.00	2,947,019,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,947,019,800.00	2,947,019,800.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	75,968,000.00	75,968,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	75,968,000.00	75,968,000.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	13,500,000.00	10,200,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,500,000.00	2,200,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00	8,000,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		43,259,557.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		289,870,582.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	127.00	127.00
620001	Удирдах ажилтан	4.00	4.00
620002	Гүйцэтгэх ажилтан	63.00	63.00
620003	Үйлчлэх ажилтан	48.00	48.00
620004	Гэрээт ажилтан	12.00	12.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	127.00	127.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	67.00	67.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	1.00	1.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1.00	1.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	46.00	46.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тус байгууллагад нэмэлт данс байхгүй байна

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь бүрэн дунд боловсрол олгох чиг үүрэгтэй байгууллага. Сургууль нь 2023 онд “Цаг үргэлж сурч хөгжин эрх үүргээ ухамсарласан нэгэн зорилгын төлөө нэгдэж, эерэг харилцаа ханалгыг эрхэмлэсэн асран хамгаалагч олон нийтийн хамтын оролцоог хангасан бүтээлч хамт олон болох” зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Нийт багш нарыг хэрэгцээ сонирхлын дагуу мэргэжлийн хөгжлийн бүлгээр ажиллуулж хөгжүүлэх нөхцөл бололцоогоор хангах
- Менежмент сайжруулах төсөлд хамт олноороо идэвх зүтгэл гарган оролцох
- Багш сурагчдыг монгол хэлний мэдлэгийг сайжруулах
- Ур чадварын уралдаан багш солилцоо хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын байрандаа мэргэжлээ дээшлүүлэх ахиж үр дүнг тооцох
- Сурагчдын сурлагын хоцрогдол үүсгэхгүй байхад анхаарч эцэг эхтэй гэрээ байгуулан ажиллаж үр дүнг тооцох
- Сургууль дотуур байрны орчин дахь хүүхэд хамгааллын талаар улирал бүр үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж эрсдэлийг бууруулах арга хэмжээ хэрэгжүүлэх
- Сургууль дотуур байрны үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх
- Хөгжлийн ялгаатай хүүхдүүдийг хамран сургах үйл ажиллагааг дэмжлэгийн багтай хамтран хэрэгжүүлэх, багш нарыг чадавхжуулах
- ЭЕШ-ын дундаж оноог судлахуун тус бүр 5 оноогоор ахиулах гэх мэт

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккрузул суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь сургуулийн захирлын 2019 оны 13 тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажилладаг байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 325.3 сая төгрөгөөр буюу 15.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өөрчлөлт
	Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		43,259.6	289,870.6	246,611.0
Авлага		72,126.2	32,602.0	(39,524.2)
Бараа материал		313,464.0	345,866.1	32,402.1
Үндсэн хөрөнгө		1,619,287.9	1,705,147.2	85,859.3
Нийт хөрөнгө		2,048,137.6	2,373,485.8	325,348.2
Өр төлбөр		-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/		2,048,137.6	2,373,485.8	325,348.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн		2,048,137.6	2,373,485.8	325,348.2

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оноос мөнгөн хөрөнгө 289.9 сая төгрөг болж 246.6 сая төгрөгөөр өссөн байна.

Авлагын данс оны эцэст 32.6 сая төгрөг болж оны эхнээс 39.5 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь цахим худалдан авалт хийж гэрээ байгуулсан компаниуд 2022 онд 72.2 сая,

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2023 онд 32.6 сая төгрөгийн бараа үйлчилгээг гэрээний хугацаанд нийлүүлээгүйтэй холбоотой гарсан авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 345.8 сая төгрөг болж 32.4 сая төгрөгөөр өссөн байна. Төсвийн хөрөнгөөр 406.0 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, Жан-Ая ХХК-иас 7.8 сая төгрөгийн зөлөөн эдлэл, аймгийн Боловсрол газраас 7.9 сая төгрөгийн багаж хэрэгсэл, сургуулийн туслах мал аж ахуйгаас 13.2 сая төгрөгийн төл бүгд 28.8 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч данс бүртгэлд тусгаж, 402.5 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1705.1 сая төгрөг болж 85.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд 38.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, өмнөх онд “Ай ти зон” ХХК, “Долоонболдог” ХХК, “Саммит компьютер технологи” ХХК-иудаас өмнөх онд цахим худалдан авалт хийсэн боловч нийлүүлээгүй бүгд 72.1 сая төгрөгийн авлагыг хүлээн авч нийт 110.9 сая төгрөгийн машин, тоног төхөөрөмжийг, тавилга эд хогшилыг хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр 69.9 сая төгрөгийн сургуулийн дотуур байрны дээврийн засвар, тавилга эд хогшил, сумын ОНХС-гийн хөрөнгөөр 18.0 сая төгрөгийн сургуулийн байрны урсгал засвар, аймгийн Боловсролын газраас 0.9 сая төгрөгийн ном сурах бичиг, засгийн газрын нөөц хөрөнгөөс 5.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, санхүүгийн программ, сум орон нутгийн шийдвэрийн дагуу 6.0 сая төгрөгийн шинээр баригдсан бага сургуулийн газар бүгд 100.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 3-р сарын 23 ны 156 дугаар тогтоолоор 0.1 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 3.2 сая төгрөгийн бусад үндсэн хөрөнгийг бүгд 3.3 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 325.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,660.0 сая, нийт зарлагыг 2,660.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Улсын төсвийн төслийн саналаас зардлыг 287.0 зардлыг сая төгрөгөөр бууруулж 2,947.0 сая төгрөгөөр баталсан байна.

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны анх батлагдсан төсөв 2,318.4 сая төгрөг ба тодотгосон төсөв 3,036.5 сая төгрөг болж анх баталснаас 718.1 сая төгрөгөөр нэмж тодотгосон байна. Энэ нь Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор тайлант оны 7 дугаар сараас цалин нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,947.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 75.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 13.5 сая төгрөг оруулж бүгд 3,036.5 сая төгрөгийн орлого санхүүжилтийг бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,947.0 сая, орон нутгийн төсвөөс 75.9 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 13.5 сая төгрөг бүрдүүлж, урьд оны үлдэгдлээс 43.2 сая төгрөг санхүүжүүлж бүгд 3,079.6 сая төгрөгийн орлого санхүүжилтээр үйл ажиллагаа явуулсан байна.

Төсвийн зарлагын нийт гүйцэтгэл 2,786.9 сая төгрөг буюу 90.5 хувьтай буюу дансанд 289.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

Нийт төсвийн зарлагын 81.1 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 2.7 хувийг тогтмол зардал, 7.3 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 0.6 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, 4.7 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 3.6 хувийг бусад урсгал шилжүүлэг тус тус эзэлж байна.

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 204.6 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 31.8 сая, нормативт зардлыг 23.7 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 1.3 сая, бараа үйлчилгээний бусад зардал 16.8 сая, бусад урсгал шилжүүлэг 15.1 сая бүгд 293.3 сая төгрөг хэмнэсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	6,268.1	4,352.5	1,915.6	69.4
80312	Сургалт семинар	3,053.7	2,288.6	765.2	74.9
81605	Эрүүл мэндийг дэмжих	5,484.2	-	5,484.2	-
81801	Үдийн цай хөтөлбөр	115,999.0	100,894.2	15,104.8	87.0
81806	Дотуур байрны үйлчилгээ	365,852.9	319,208.8	46,644.1	87.3
81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	71,139.3	68,031.0	3,108.3	95.6
81823	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	15,318.1	10,235.0	5,083.1	66.8
81827	Бичиг үсгийн боловсролын хөтөл	12,075.0	4,776.5	7,298.5	39.6
81834	Боловсролын стандарт, сургалты	1,890,907.0	1,698,165.4	192,741.6	89.8
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	504,182.1	500,456.8	3,725.3	99.3
81844	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	10,150.7	-	10,150.7	-
81848	Сурах бичгийн тїрээс	3,500.0	2,200.0	1,300.0	62.9
80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	75,968.0	75,968.0	-	100.0
	Дүн	3,079,898.1	2,786,576.8	293,321.3	90.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Сургууль нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 406.0 сая төгрөгийн бараа материал, цахим худалдан авалтаар 110.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авч данс бүртгэлд тусгасан байна.

АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Манаргүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,837,6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 42.6 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзэв

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсвийг хэмнэх талаар 29 арга хэмжээний хэрэгжилтийг шалгаж үзэхэд алдаа зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2023 онд нийт 2710.7 сая төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилт 100 хувь байна. Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн шийдвэрийг байршуулсан байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн, хяналт дотоод аудитын албанаас шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн төсвийн зарцуулалт нь Төсвийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар нийт 21.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1.3 сая төгрөгийн 2 албан шаардлага, 18.0 сая төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг давтан шалгаж үзэхэд бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1877.0	1	1877.0	100%
Албан шаардлага	2	1310.1	2	1310.1	100%
Зөвлөмж	1	17999.1	1	17999.1	100%
Нийт дүн	4	21186.2	4	21186.2	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйл гараагүй. Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж тус байгууллагын санхүүжилтийн зарцуулалтын тооцоог бүрэн шалгах боломжгүй, зөвхөн санхүүгийн тайлан гаргалтыг шалгаж баталгаажууллаа.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй, сурах бичгийн түрээсийн орлогыг аккурэл сууриар бүртгэж тайлагнаагүй байсан асуудалд зөвлөмж өгөв.

Аудитаар 33.3 сая төгрөгийн зөрчил илэрч зөвлөмж өгөгдлөө.

5.1 Төлбөрийн акт

Тогтоосон төлбөрийн акт байхгүй

5.2 Албан шаардлага

Албан шаардлага байхгүй

5.3 Зөвлөмж

Аудитаар 33.3 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөгдлөө.

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Цалингийн зардлаас 126 багш, ажилчдад 33.3 сая төгрөгийн түлээ нүүрний хөнгөлөлт олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал"-тай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу зардлын эдийн засгийн ангиллыг мөрдөж, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Сурагчдад олгосон сурах бичгийн түрээсийн орлогыг аккурэл сууриар бүртгэж тайлагнаагүй байна.

2.1. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө" гэсэн заалтыг мөрдөж сурах бичгийн түрээсийн орлогыг аккурэл сууриар бүртгэж тайлагнах, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг бэлтгэх аргачлал, зааврыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Сурах бичгийн түрээсийн орлогыг аккурэл сууриар бүртгэж тайлагнаагүй байна	1	0.0										1	0.0
ДҮН	1	0.0										1	0.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалингийн зардлаас түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон	1	33,302.4					1	33,302.4				
Дүн	1	33,302.4					1	33,302.4				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Төрийн хэмнэлттэй холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								